



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/248

Ховд

Улсын комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн “а”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан Ховд аймгийн Жаргалант сумын Бугат багт инженерийн хийцтэй ухаалаг худаг гаргах ажлыг хүлээн авах улсын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга: Б.Баярсүх - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Б.Туулайтулга - Жаргалант сумын Засаг даргын орлогч
М.Цогт-Эрдэнэ - Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мэргэжилтэн

Д.Тогтохбаяр - Газрын харицаа, барилга хот байгуулалтын газрын барилгын хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн

Т.Бямбажаргал - Байгаль орчны газрын усны асуудал хариуцсан мэргэжилтэн

Г.Цэдэнбал - Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч

З.Уянга - Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн мэргэжилтэн

Б.Түмэндэлгэр - Бугат багийн Засаг дарга

Б.Түмэнжаргал - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

С.Баньдхүү - “Алтайн хар сувд” ХХК-ийн захирал

Zax A/248 Ch

02 1503

Нарийн бичгийн
дарга Г.Билгүүн - Аймгийн засаг даргын дэргэдэх зөвлөх
багийн гишүүн

2. Инженерийн хийцтэй ухаалаг худгийн гүйцэтгэл, бичиг баримтыг шалган, санхүүжилтийг олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт даалгасугай.

3. Тухайн ажлыг ажлын даалгавар, зураг төсөвтэй тулган шалгаж, норм нормативыг баримт бичигт заасан техникийн үзүүлэлт, шаардлагын дагуу гүйцэтгэсэн эсэхийг хянан баталгаажуулж, шийдвэр гаргахыг улсын комиссын дарга /Б.Баярсүх/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН